



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 02-р сарын 16-ний өдөр

№ 09

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Инвекор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.18 дах заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.16 дахь заалт, болон “Ногдол ашгийн бодлого”-ын 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 4,014,446,893 (дөрвөн тэрбум арван дөрвөн сая дөрвөн зуун дөчин зургаан мянга найман зуун ерэн гурав) төгрөгийн ногдол ашгийг Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай;
2. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 53 (тавин гурав) төгрөгөөр тогтоосугай;
3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай;
4. Энэхүү тогтоолын 2-т заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК- аар дамжуулан 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Компанийн хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай;
5. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

